



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 01 сарын 20 өдөр

Дугаар A/16

Арвайхээр

Цалин шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.1, 57.2.2, Засгийн газрын “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2019 оны 472 дугаар тогтоолын 2, 11 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга нарын албан тушаалын цалинг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Цалин шинэчлэн тогтоосонтой холбогдуулан төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн хүний нөөцийн системд цалин хөлс, нэмэгдлийн мэдээллийг шинэчлэн оруулахыг аймгийн Засаг дарга Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д даалгасугай

3. Шинэчлэн тогтоосон цалинг 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн тооцож олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (О.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан “Цалин шинэчлэн тогтоох тухай” 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/32 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100035

Аймгийн Засаг даргын 2020 оны 01 дугаар сарын 20-ны өдрийн 416 дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ, ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА НАРЫН ШИНЭЧЛЭН ТОГТООСОН ЦАЛИН

№	Ажилтнуудын нэрс	Ангилал зэрэглэл	Албан тушаалын цалин	Нэмэгдэл /хувиар/					
				Онцгой нөхцөлийн	Төрийн алба хаасан хугацааны	Төрийн албаны зөвлөл	Мэргэжлийн зэрэг	Нууц	Зэрэг дэв
1	О.Батжаргал	УТ	1051067	30					
2	И.Доржсүрэн	УТ	1051067	30					
3	Ц.Ганболд	ТЗ-12-5	1151108		15	20	15	10	38

-оОо-